



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ”  
ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэлд  
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гаргасан хувьцааг 182,194,989 /нэг зуун наян хоёр сая нэг зуун ерэн дөрвөн мянга есөн зуун наян ес/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 361,330,952 /гурван зуун жаран нэгэн сая гурван зуун гучин мянга есөн зуун тавин хоёр/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК / Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж. Алдаржавхлан /-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол ирүүлж, хууль тогтоомж болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /Ч.Баттуяа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З. НАРАНТУЯА

000944